

Захиалагч:
Эрүүл мэндийн хөгжлийн төвийн
захирал


Ч Бат-Эрдэнэ
1440456 9080231

БАТЛАВ.

Үйлдвэрлэгч:
“Үндэсний Үнэт Цаас” ХХК-ийн
Гүйцэтгэх захирал


Д.Түмэнжаргал
MNSPC
УХН8422 2077264

ГЭРЭЭ

**Эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн зэргийн
үнэмлэх хэвлэх тухай**

Дугаар SP 16044

2016 оны 07 сарын 19

Улаанбаатар хот

Энэ гэрээг нэг талаас Эрүүл мэндийн хөгжлийн төв/ цаашид захиалагч гэх/-ийг төлөөлж ЭМХА-ны дарга Д.Уранчимэг, нөгөө талаас “Үндэсний Үнэт Цаас” ХХК-ийг төлөөлж Эдийн засагч Ч.Шинэтуяа цаашид үйлдвэрлэгч гэх/ нар нь талуудын хоорондын эрх үүрэг, хариуцлагыг харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

Нэг. Гэрээний зүйл

1.1. Үйлдвэрлэгч нь захиалагчийн захиалсан эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн зэргийн үнэмлэх /цаашид бүтгээдэхүүн гэх/-ыг нийт 1030 ширхэгийг дараах үнэ, төрөл, тоо хэмжээ, дугаартайгаар чанарын өндөр түвшинд хэвлэх ажлыг хийж гүйцэтгэнэ. Үүнд:

төгрөгөөр

№	Төрөл	Дугаар	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ
1	ЭММЗҮнэмлэх	0006321-0007350	1030	1100	1,133,000
				Нийт үнэ /НӨАТ 10%-тай/	1,133,000

1.2. Энэхүү гэрээгээр үйлдвэрлэгч нь мэргэжлийн зэргийн үнэмлэхийг захиалагч нь загварыг баталснаас хойш 10 хоногийн дотор хэвлэн нийлүүлэх ба худалдааны татвар 10%-ийн хамт нийт **1,133,000** /нэг сая нэг зуун гучин гурван/ төгрөгийг бэлнээр буюу үйлдвэрлэгчийн Голомт банкин дахь 1102596741 тоот дансанд гэрээ байгуулснаас хойш 3 хоногийн дотор хийнэ.

Хоёр. Үйлдвэрлэгчийн хүлээх эрх үүрэг, хариуцлага

2.1 Үйлдвэрлэгч энэхүү гэрээнд заасан хугацаанд нууцлалын болон чанарын шаардлагыг бүрэн хангасан барааг захиалагчид үйлдвэрлэн нийлүүлнэ.

2.2 Захиалагч барааг хүлээн авахаас өмнө үйлдвэрлэлийн ажиллагаанаас болж гэмтээснээс үүсэн гарах хариуцлагыг үйлдвэрлэгч хариуцна.

2.3 Үйлдвэрлэгч захиалагчид чанарын шаардлага хангахгүй бараа нийлүүлсэн бол гологдолтой тоо хэмжээгээр нь шинээр сольж өгнө. Шаардлага хангаагүй барааг актаар хүлээн авч хамтран устгал хийнэ.

2.4 Үйлдвэрлэгч нь бараа үйлдвэрлэхтэй холбоотой үйлдвэрлэлийн нууцлалыг бүрэн хариуцна.

2.5 Үйлдвэрлэгч нь бараанаас загвар болох зориулалтаар төрөл тус бүрээс 3 /гурав/ ширхэгийг өөрийн архивтаа авч үлдэнэ. Архивт авсан гурван ширхэг бүр нь эх загвар болж гарын үсэг зурагдсан байна.

2.6 Захиалагч тал барааг хүлээн авахдаа баглаа боодлын битүүмжлэл тоо ширхгийг шалган авна.

2.7 Үйлдвэрээс лацдаж захиалагчид нийлүүлсэн барааны тоо хэмжээ дутсан тохиолдолд тоо хэмжээгээр нь тус барааг нөхөж өгнө.

Гурав. Захиалагчийн хүлээх эрх үүрэг, хариуцлага

3.1 Шаардлагатай гэж үзвэл үйлдвэрлэлт нийлүүлэлттэй холбогдолтой асуудлаар өөрийн санал хүсэлтээ бараа хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор Үйлдвэрлэгчийн албан ёсны хаягаар бичгээр ирүүлнэ.

3.2 Захиалагч барааны төлбөр тооцоог энэхүү гэрээний 4.1-д заасны дагуу хийж гүйцэтгэнэ.

3.3 Захиалагч хүлээн авсан барааг ашиглах үед хэвлэлийн чанарын гологдол гарвал үйлдвэрлэгчид ажлын 5 хоног дотор акт үйлдэн буцаана.

3.4 Хэрэв захиалагч нь үйлдвэрлэгчээс хүлээн авсан барааны боодлыг задлахын өмнө Үйлдвэрлэгчийн хамгаалалтын албаны болон чанарын мастерыг урьж задалж тоолоход байлцахыг хүсвэл Үйлдвэрлэгч энэ саналыг заавал хүлээн авна.

3.5 Устгал, хяналтын тооцооны ажлыг хийхэд дуудсан хугацаанд төлөөлөгчөө байлцуулна.

Дөрөв. Төлбөр тооцоо хийх

4.1 Хэрэв захиалагч барааны төлбөрийг 4.1-р зүйлд заасны дагуу хийгээгүй тохиолдолд хэтрүүлсэн хоног тутамд төлбөл зохих төлбөрийн 0.5%-тай тэнцэх хэмжээний алдангийг нэхэмжилнэ.

4.2 Үйлдвэрлэгч гэрээнд заасан хугацаанд барааг нийлүүлж чадахгүй бол хэтрүүлсэн хоног тутамд нийт үнийн дүнгийн 0.5%-ийн алдангийг Захиалагчид төлнө.

4.3 Нийлүүлсэн барааны тоо дутагдвал баглаа боодлыг нээж тоолсноос хойш 7 хоногийн дотор үйлдвэрлэгч захиалагчийн төлөөлөгчид хамтран шалгаж, хамтарсан акт бичнэ.

4.4 Үйлдвэрлэгч захиалагчид чанарын шаардлага хангахгүй бараа нийлүүлсэн бол гологдолтой хэмжээгээр нь барааны хэвлүүлсэн үнийг нөхөн төлнө.

4.5 Барааны үйлдвэрлэлийн бус механик гэмтлүүдийг /урсан, норсон г.м/ үйлдвэрлэгч хариуцахгүй.

Тав. Давагдашгүй хүчин зүйл.

5.1 Давагдашгүй хүчин зүйл /байгалийн гамшиг, гал түймэр, үер, аянга, газар хөдлөлт, хүчит салхи шуурга, хөрсний сууртас үүсэх цөмрөлт, цахилгаан станцын хүнд гэмтэл саатал г.м./-ээс гарах хохирлыг талууд хүлээхгүй.

Зургаа. Бусад зүйл.

6.1 Хоёр талын гарын үсэг зурснаар энэхүү гэрээ хүчин төгөлдөр болох бөгөөд түүнийг 2 хувь үйлдэнэ. Хувиуд нэгэн адил хууль зүйн хувьд хүчинтэй байна.

6.2 Аливаа маргаантай асуудал гарвал хоёр тал эвийн журмаар харилцан хэлэлцэж 1 сарын дотор шийдвэрлэх бөгөөд энэ хугацаанд шийдвэрлээгүй бол шүүхийн байгууллагаар маргааныг шийдвэрлүүлнэ.

Гэрээ байгуулсан:

Захиалагчийн хаяг:

Эрүүл мэндийн хөгжлийн төв

Энхтайваны гудамж 13/б

Утас: 98201588

Захиалагчийг төлөөлж:

ЭМХА-ны дарга

/Д.Уранчимэг/

Үйлдвэрлэгчийн хаяг:

"Үндэсний Үнэт Цаас" ХХК

Жуулчны гудамж- 10/1

Чингэлтэй дүүрэг

Данс: Голомт Банк 1102596741

Утас: 327102, 327115

Үйлдвэрлэгчийг төлөөлж:

Эдийн засагч:

/Ч.Шинэтуяа/